

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20..оны ...дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт, хэсгийг нэмсүгэй.

1/6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дах заалт

6.1.5 төрийн үйлчилгээ болон дэд бүтцийг ашиглан үүссэн мэдээллийн ил тод байдал

2/2 дугаар бүлгийн 10¹ дүгээр зүйл

10¹ дүгээр зүйл. Төрийн үйлчилгээ болон дэд бүтцийг ашиглан үүссэн мэдээллийн ил тод байдал

10¹.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээ болон дэд бүтцийг ашиглан үүссэн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

10¹.1.1. Өөрийн үзүүлж буй үйлчилгээ болон төрийн дэд бүтцийг ашиглуулсны үр дүнд үүсэн хуримтлагдаж буй мэдээллийг цагийн хоцрогдолгүйгээр тухай бүр шинэчлэн энэхүү хуулийн 16.5-аар тодорхойлогдсон үйлчилгээний хөлсөөр иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр нийлүүлж болно.

10¹.1.2. Энэ хуулийн 6.1.5-д заасан мэдээллийн төрөл, багтаах өгөгдлийн загвар, өгөх хэлбэрийг тогтоосон журмыг Засгийн Газар батлана.

3/3 дугаар бүлгийн 16 зүйлийн 4 дэх хэсэг

16.5. 6.1.5-д заагдсан мэдээллийн үйлчилгээний хөлсийг Засгийн Газраас батлах бөгөөд шууд зардлаар хязгаарлахгүй.

2 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

16.4. Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4-д заагдсан мэдээллийн үйлчилгээний хөлс нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас хэтэрч болохгүй.

Гарын үсэг

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20..оны ...дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/15 дугаар зүйлийн 3 дах заалт

15.3 Энэ хуулийн 15.2-т заасан төлбөрийн хэмжээг Засгийн Газар тогтооно.

Гарын үсэг